

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн Р-2023-44 дүгээр тогтоолын Хавсралт



**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД БОЛОН АЖИЛТНУУДЫН ЁС ЗҮЙН
КОДЕКС БА СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЕРӨНХИЙ ЖУРАМ**

Улаанбаатар, Монгол улс

2023 оны 7 дугаар сарын 06-ний өдөр



Компани	ХасБанк ХК
Хянах огноо	2025 оны .. дүгээр сарын ..
Баталсан	Төлөөлөн Удирдах Зөвлөл Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх ххх хороо
Боловсруулсан	Комплаенсийн хэлтэс/ Төлөөлөн удирдах зөвлөлийн ажлын алба
Холбогдох эрх зүйн бичиг баримтууд	Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх бодлого Хөдөлмөрийн дотоод журам Шүгэл үлээх бодлого ХасБанкны нууцын журам
Дагаж мөрдөх	ХасБанкны хэмжээнд
Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох, шинэчлэн батлах	Энэхүү журамд оруулах аливаа нэмэлт өөрчлөлтийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор батална

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. УДИРТГАЛ

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ЁС ЗҮЙН ТӨЛӨВ БА ЗАН ҮЙЛ

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААНД
БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ҮЙЛ ЯВЦ БА ХАРИУЦЛАГА

ТАВДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ТОЛИЛУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХОЛ

НАЙМДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА БА ЗАРЧИМЧ БАЙДАЛ

АРАВДУГААР ЗҮЙЛ. НУУЦЛАЛ

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУУЛЬ ТОГТООМЖ БА ЗАСАГЛАЛ

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ. НИЙТЭД ХИЙХ МЭДЭГДЭЛ

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭМ БУРУУТАЙ НЬ ТОГТООГДОХ

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЯНАН НИЙЦҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

АРВАНТАВДУГААР ЗҮЙЛ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД БОЛОН АЖИЛТНУУДЫН
ЁС ЗҮЙН КОДЕКС БА СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЕРӨНХИЙ ЖУРАМ

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. УДИРТГАЛ

- 1.1 Ёс зүйн кодексийн ("Кодекс") зорилго нь ХасБанк ХК ("Банк")-ийн бизнесийн үйл ажиллагааг хууль ёсны бөгөөд ёс зүйтэй байлгах үүднээс ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлах, мөн тус стандарт ба ёс зүйд тулгуурласан зан суртахууны соёлыг Банкны Хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гишүүд, Банкны удирдлага бий болгож, нийт ажилтнуудад дагаж мөрдүүлэх үйл ажиллагааны оролцоог илтгэхэд оршино.
- 1.2 Энэхүү Кодекс нь Банкны үнэ цэнийг урт хугацаанд өсгөн, хадгалахад зориулагдаж, Банкны үйл ажиллагаанд эрх зүй, ёс зүй, мэргэжлийн хариуцлагын стандартыг баримталсан мөнхүү кодексийг дагаж мөрдөнө.
- 1.3 Энэхүү Кодекс нь харилцагч, нийлүүлэгч, зээлдүүлэгч, ажилтнууд, хянан шалгагч, зохицуулагч байгууллагын дунд Банкны бизнесийн нэр хүнд, хүндэтгэлийг бэхжүүлж хамгаалахад чиглэгдэнэ.
- 1.4 Энэхүү Кодексийг Төлөөлөн удирдах зөвлөл баталж, Гүйцэтгэх удирдлага Банкны хэмжээнд нэвтрүүлж, хэрэгжилтийг хариуцна. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэх удирдлагаас дотоод сургалтыг тогтмол зохион байгуулна.
- 1.5 Төлөөлөн удирдах зөвлөл нь Кодексийн хэрэгжилт, мөн илэрсэн аливаа зөрчлийг жил бүр хянан үзэж, шаардлагатай шинэчлэл, өөрчлөлтийг оруулна.
- 1.6 Энэхүү Кодекс нь Банкны ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд нэг бүрийн баримтлах ёс зүйн хэм хэмжээ, мэргэжлийн болон зан төлөвийн шаардлагыг тодорхойлж, түүнийг хангуулах, хэрэгжилтийг нь үнэлэх, хянан нийцүүлэхэд оршино.
- 1.7 Кодексийг ХасБанк ХК-ийн дүрэмтэй уялдуулан хэрэгжүүлэх бөгөөд Банкны ёс зүй ба зан үйлийн харилцааг зохицуулсан бусад хууль тогтоомжид дэмжлэг үзүүлэх зорилготой.
- 1.8 Банкны ашиг сонирхлыг хамгаалах, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчид болон олон нийтийн итгэлийг бэхжүүлэхийн тулд энэхүү Кодекс нь Монгол Улсад үйлчилж байгаа хууль тогтоомжийн шаардлагаас дээгүүр, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүн туршлага, зарчмуудад үндэслэсэн болно.
- 1.9 Энэхүү Кодексийг Банкны дүрэмтэй хамт мөрдөж, тогтмол шинэчлэн өөрийн хууль ёсны бөгөөд ёс зүйтэй үйл ажиллагаа, компанийн сайн засаглалыг дэмжин манлайлж буйгаа харуулна.
- 1.10 Банкны ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь энэхүү Кодекс болон зохицуулагч

байгууллага, мэргэжлийн холбооноос баталсан ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

- 1.11 Энэхүү Кодексод хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:
- 1.11.1 “Ёс зүйн хэм хэмжээ” гэж холбогдох хууль тогтоомж, Банкны бодлого, журам, зохицуулалт, заавар, Хөдөлмөрийн гэрээ, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан албан үүргээ гүйцэтгэхдээ хувь хүний хандлага, зан үйлийн харилцаанд дагаж мөрдөхөөр тогтоосон хэм хэмжээг;
- 1.11.2 “Ёс зүйн зөрчил” гэж Банкны Хөдөлмөрийн дотоод журмын 1.6.27-д “Банкны дүрэм, журам, заавар, Хөдөлмөрийн гэрээ, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ, Ажилтны ёс зүйн эрхэмлэх зүйлд заасан нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшилсан, Банкны нэр хүндийг гутаах, бусдад тааламжгүй сэтгэгдэл төрүүлэхүйц нөхцөл байдлыг бүрдүүлсэн үйлдлийг” гэж тодорхойлсныг;
- 1.11.3 “Сонирхлын зөрчил” гэж Банкны ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд өөрийн мэргэжлийн буюу албан тушаалын эрхээ аливаа хэлбэрээр өөрсдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах эсвэл Банкны үйл ажиллагаанд нөлөөлөн гаргаж буй шийдвэр нь Банканд хохирол учруулан ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд, түүний гэр бүл, бизнесийн холбоотой этгээдэд санхүүгийн ашиг орлогыг шууд буюу шууд бус замаар бий болгох зэрэг бусдад зүй бус давуу тал олгох нөхцөл байдлыг;
- 1.11.4 “Бизнес түншүүд” гэж Банкны үйл ажиллагаанд шаардлагатай бараа, ажил, үйлчилгээг холбогдох гэрээний үндсэн дээр нийлүүлж буй хуулийн этгээдийг.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ЁС ЗҮЙН ТӨЛӨВ БА ЗАН ҮЙЛ

- 2.1 Банк нь өөрийн бизнесийн бүхий л үйл ажиллагаандаа ёс зүйтэйхандана.
- 2.2 Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэнэ.
- 2.3 Энэхүү ёс зүйн хэм хэмжээг хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчид, ажилтнууд, харилцагчид, бизнесийн түншүүд, засгийн газар, нийгэм дэх өргөн олныг багтаасан нийт оролцогч талуудтай харилцах харилцаанд баримтална.
- 2.4 Ёс зүйн хэмжээ нь Банкны Монгол болон гадаад дахь бүхий л салбарын бизнесийн үйл ажиллагаанд мөрдөгдөнө.
- 2.5 Банкны ёс зүйн хэм хэмжээ нь дараах шаардлагад үндэслэнэ:
- 2.5.1 Банкны үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийг дагаж мөрдөх;
- 2.5.2 Банкны санхүү, үйл ажиллагааны гүйцэтгэлийг удирдаж хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны үнэ цэнийг өсгөх;

- 2.5.3 Бизнесийг шударга, зарчимтай явуулах үүднээс авлига, хахууль зэрэг бизнесийн буруу практикийг үл зөвшөөрч, бизнесийн заншилд тооцогддог, материаллаг бус, ховор гэж тооцогдохоос бусад тохиолдолд шан харамж бэлэг сэлт, тус дэмжлэг бусдаас авах, шаардах, мөн тэдгээрийг бусдад нөлөөлөх зорилгоор өгөхгүй байх;
- 2.5.4 Банкны харилцаанд харилцан ашигтай давуу талыг бий болгох замаар итгэлцлийг үүсгэн хөгжүүлэх;
- 2.5.5 Үйл ажиллагаа эрхлэн явуулж буй газрын өргөн олон, нийгэм, байгаль орчныг хүндэтгэх;
- 2.5.6 Мэдээллийн нууцлал, дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаа, нууцлалын талаарх бүхий л бодлогыг дагаж, нууцлал бүхий нийтэд ил болоогүй буюу дотоод мэдээллийг хувийн санхүүгийн ашиг сонирхолд ашиглахгүй байх;
- 2.5.7 Сонирхлын зөрчил үүсэж болзошгүй аливаа нөхцөл байдлын талаарх бүрэн гүйцэд, шударга, үнэн зөв, хүндэтгэн үзэж болохуйц мэдээллийг цаг тухайд нь мэдээлэх;
- 2.5.8 ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд Банкны нэр хүндийг гутаасан үг, үйлдлээс татгалзаж, Банкны эрх ашиг, нэр хүндийг хамгаалж, улс төрийн нөлөө, эвсэл, хөдөлгөөн, намд улс төрийн хандив өгөх зэргээс ангид байж улс төрийн төвийг сахисан байр суурийг баримтлах үүрэгтэй.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААНД БАРИМТЛАХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

3.1 Ажилтнууд:

- 3.1.1 Бүх ажилтнууддаа нэр төртэй, итгэл хүндэтгэлтэй, өрөөсгөлдөлгүй, ялгаварлан гадуурхалгүй хандаж Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомж, хүний эрхийг дээдлэх зарчимд үндэслэсэн урт хугацааны харилцааг үүсгэн хөгжүүлэх;
- 3.1.2 Хүүхдийн хөдөлмөрийг ашиглахгүй байх;
- 3.1.3 Багаар ажиллах, тал бүрийн авьяас, үзэл санаа, саналыг дэмжиж бизнесийн шинэ бүтээлч боломж, санаачилгыг хөхүүлэн дэмжих;
- 3.1.4 Үйл ажиллагаанд саад тотгор болох хүнд суртлын аливаа хэлбэр, илүү шат дамжлагаас татгалзах;

- 3.1.5 Эрүүл, аюулгүй, тогтвортой хөдөлмөрийн нөхцөлөөр ажилтнуудаа хангантүүнийг байнга сайжруулж байх;
- 3.1.6 Зохистой толилуулга мэдээлэл хийж байх
- 3.1.7 Үл ялгаварлах зарчим, ур чадварт үндэслэсэн ажил олгох, дэвшүүлэх, урамшуулах тэгш боломжийг олгосон ажил олгогч байх;
- 3.1.8 Бэлгийн дарамт зэрэг ажлын байран дээрх аливаа төрлийн дарамт, гадуурхалтыг зохих журмын дагуу илрүүлж шийдвэрлэх;
- 3.1.9 Ажилтнуудыг зорилтоо хэрэгжүүлсэн гүйцэтгэлд үндэслэн багийн болон хувийн амжилтаар нь үнэлж урамшуулах;
- 3.1.10 Дадлагажуулах, дагалдуулах сургалтын хөтөлбөрт ажилтнуудыг хамруулж тэдний ур чадварыг сайжруулах хувийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах;
- 3.1.11 Ажилтнуудын хувьцаа эзэмших хөтөлбөрийг дэмжих;
- 3.1.12 Нийт ажилтнууд Банкны нууц болон дотоод мэдээллийг хууль бусаар ашиглахыг хориглох;
- 3.1.13 Хөдөлмөрийн нөхцөл, ажлын орчинд нөлөөлөх болон түүнд хамаарах бусад асуудлаар Банкны ажилтнууд ба удирдлагын хооронд байнгын зөвлөлдөх арга хэмжээг зохион байгуулах;
- 3.1.14 Ажилтныг ажлаас халагдах, хариу арга хэмжээ авахаас айх эмээх зүйлгүйгээр удирдлагадаа мэдээлэл өгөх, мэдээллийн нууцыг хадгалах, шуурхай шалгаж шийдвэрлэх болон хувийн мэдээллээ нууцлан мэдээлэл өгөхийг дэмжих;
- 3.1.15 Монгол Улсын хөдөлмөрийн хууль тогтоомжийн дагуу хөдөлмөрийн сахилга батыг сахиулах, ажлаас чөлөөлөх.

3.2 Харилцагчид:

- 3.2.1 Харилцагчдын сэтгэл ханамж бол Банкны эрхэмлэх зүйл мөн. Баталгаатай бөгөөд чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, шударга үнэ, ил тод борлуулалтын дараах зохистой үйлчилгээ болон урт хугацааны харилцаа нь Банкны харилцагчдадаа хандах харилцааг тодорхойлно.
- 3.2.2 Банк нь өөрийн өгсөн амлалтаа биелүүлэхийг үргэлж эрмэлзэх болно.

3.3 Бизнесийн түншүүд:

- 3.3.1 Бизнесийн түншүүдтэйгээ хүндэтгэл, итгэл, чин сэтгэл, шударга зарчимд тулгуурласан урт хугацааны харилцааг бүрдүүлэх;
- 3.3.2 Гэрээний үүрэг, бизнесийн харилцаагаа эрхэмлэн дээдлэх;
- 3.3.3 Харилцан ашигтай байх зарчимд тулгуурласан гэрээ, хэлцэл байгуулах;
- 3.3.4 Бизнесийн харилцаа нь гүйцэтгэлийн өндөр стандартад үндэслэсэн байх явдлыг хангах;
- 3.3.5 Арилжааны маргаан гарах нөхцөлд боломжит шийдэлд хүрэхийн тулд чин сэтгэлээс харилцан буулт хийх замаар тохиролцоонд хүрэхийг эрмэлзэх;
- 3.3.6 Монгол Улсын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (AML) болон харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа (KYC)-тай холбоотой хууль тогтоомжийг дагаж мөрдөх;
- 3.3.7 Нэр хүнд бүхий бизнесийн түншүүд, харилцагчид, бусад түншүүдтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах.

3.4 Засгийн газар, төрийн байгууллага:

- 3.4.1 Татвараа цаг хугацаанд нь үнэн зөв, бүрэн төлдөг байх;
- 3.4.2 Хууль тогтоомж, дүрэм, журмыг дагаж мөрдөх;
- 3.4.3 Банкны үйл ажиллагаа эрхлэхэд чиглэгдсэн холбогдох тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжийн дагуу авах;
- 3.4.4 Төрийн эрх бүхий байгууллагуудтай харилцан ашигтай харилцааг бий болгох, удирдах;
- 3.4.5 Засгийн газар, зохицуулагч байгууллага, төрийн захиргааны байгууллага, шүүхийн байгууллагатай харилцахдаа хөлс төлөхийг санал болгох, авлига, хахууль өгөх зэрэг ёс бус үйлдлээс татгалзах;
- 3.4.6 Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, эсвэл засгийн газрын мөн түүний албан тушаалтны өмчлөл, удирдлагад байдаг компанитай хийх гүйлгээ хэлцлийг зохицуулах ил тод журмыг гаргах.

3.5 Нийгэм ба хүрээлэн буй орчин:

- 3.5.1 Банкны салбар, тооцооны төв нь үйл ажиллагаа явуулж буй газрынхаа орон нутгийн олон нийттэй хүндэтгэл, итгэлцэл, чин сэтгэл, шударга зарчимд үндэслэсэн эрүүл харилцааг тогтоож удирдах;
- 3.5.2 Ажлын байрыг бий болгох, тухайн орон нутгийн иргэдийн авьяас чадварыг хөгжүүлэх;
- 3.5.3 Хог хаягдлыг багасгах, эрчим хүчийг хэмнэлттэй ашиглах, үйл ажиллагааг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрсөн зарчмын дагуу эрхлэх замаар Банкны үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлийг баримтлах;
- 3.5.4 ТУЗ-ийн гишүүд, ажилтнаас өөрийн мэдлийн цагийг буяны байгууллага, сан, боловсролын байгууллага зэрэг адил төстэй байгууллагын үйл ажиллагаанд туслахад зарцуулахыг дэмжих;
- 3.5.5 Эдийн засгийн хувьд тогтвортой нийгэм ба байгаль орчныг бүрдүүлж хамгаалах чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагатай бүтээлч хамтын ажиллагаа тогтоож, хөгжүүлэх;
- 3.5.6 Байнгын, нээлттэй хамтын ажиллагааг өрнүүлэх замаар Банкны салбар, тооцооны төвийн үйл ажиллагаа явуулж буй орон нутгийн хөгжлийн тусгайлсан эрэлт хэрэгцээг харгалзан үзэх чиглэл баримтлах.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ҮЙЛ ЯВЦ БА ХАРИУЦЛАГА

- 4.1 ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд нэг бүр өөрийн ёс зүйн үйлдэл, энэхүү Кодексийн хэрэгжилтийн төлөө хариуцлага хүлээнэ.
- 4.2 Энэхүү Кодексийг ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд заавал мөрдөх бөгөөд ТУЗ-ийн гишүүнтэй байгуулах гэрээ болон ажилтантай байгуулах хөдөлмөрийн гэрээнд тусгах бөгөөд сахилгын арга хэмжээ авах зохицуулалттай уялдуулна.
- 4.3 Энэхүү Кодекс нь Банкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдох урьдчилсан нөхцөл болно.
- 4.4 Энэхүү Кодексийг нийт ажилтнуудад нээлттэй байхаар Банкны дотоод сүлжээнд байршуулах бөгөөд шинээр ажилд орсон ажилтан бүрд заавал танилцуулна.
- 4.5 Банкны ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь энэхүү Кодексийн заалтыг ойлгож, хэрэгжүүлж байгаагаа тогтмол мэдэгдэнэ.

- 4.6 Газар хэлтсийн захирлууд нь өөрсдийн удирдаж буй газар хэлтэст хамаарах нийт ажилтнууд энэхүү Кодексийг ойлгож, хэрэгжүүлж байгаад хяналт тавих бөгөөд Кодексийн хэрэгжилтийг Гүйцэтгэх захирал болон хариуцсан захирлуудын өмнө хариуцна. Гүйцэтгэх захирал болон хариуцсан захирлууд нь ТУЗ-ийн өмнө Кодексийн хэрэгжилтийг хариуцна.
- 4.7 Энэхүү Кодексийн зарчим ба заалтууд нь компанийн дотоод эрх зүйн тогтолцоонд тусгалаа олсон байна.
- 4.8 Энэхүү Кодексийг санаатайгаар болон санамсаргүйгээр зөрчих үйлдэл болон эс үйлдэл нь ТУЗ-ийн гишүүн болон ажилтантай үүсгэсэн хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах үндэслэл болно.
- 4.9 ТУЗ-ийн аудитын хороо нь энэхүү Кодексийн хэрэгжилтийг тухай бүр хянаж, холбогдох саналыг боловсруулан ТУЗ-д оруулж байна.

ТАВДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

- 5.1 ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд Банкны ашиг сонирхлын төлөө шударга, бусдын нөлөөлөлд авталгүй шийдвэр гаргахад хөндлөнгөөс нөлөөлөхүйц бодитой буюу боломжтой сонирхлын зөрчлөөс зайлсхийнэ.
- 5.2 Сонирхлын зөрчлийг Банкны ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд өөрийн мэргэжлийн буюу албан тушаалын эрх мэдлээ аливаа хэлбэрээр өөрсдийн хувийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглах, Банкны үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэр гаргах, холбогдох шийдвэр нь ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд, түүний гэр бүл, бизнесийн холбоотой этгээдэд санхүүгийн ашиг орлогыг шууд буюу шууд бус замаар бий болгох, эсвэл Банкинд хохирол учруулахуйц зүй бус давуу талыг бусдад олгох аливаа нөхцөл байдлыг ойлгоно;
- 5.3 Сонирхлын зөрчил бүр санхүүгийн боломж, давуу талыг бий болгохгүй байж болох бөгөөд сонирхлын зөрчил нь бодитой бус, ойлголт байж болох тул ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь Банкны ашиг сонирхол, үйл ажиллагааг хамаарч болзошгүй нөхцөл байдалд өөрсдийн харилцаа, зан үйлдээ анхаарал, болгоомжтой хандах үүрэгтэй.
- 5.4 Холбоотой этгээд гэдэгт дараах этгээд орно:
 - 5.4.1 ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлагын баг эсвэл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч;
 - 5.4.2 Сүүлийн 12 сарын хугацаанд Банкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан аливаа этгээд;
 - 5.4.3 Гэр бүлийн гишүүн;
 - 5.4.4 5.4.1, 5.4.2, 5.4.3-т заасан этгээдүүд нь хувьцаа эзэмшигчдийн хуралд

саналын 50 хувиас дээш хувийн эрхтэйгээр оролцдог эсхүл ТУЗ-ийн бүрэлдэхүүний олонход хяналт тавих боломжтой этгээд.

5.5 Сонирхлын зөрчилд дараах зүйлс хамаарна:

5.5.1 Холбоотой этгээдтэй хийх гүйлгээ;

5.5.2 Холбоотой этгээдийг хамруулсан Засгийн газартай хийх гүйлгээ;

5.5.3 Өөртэйгөө арилжаа, хэлцэл хийх буюу Банкны ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх удирдлага, холбоотой этгээдийн эсвэл ажилтнууд нь албан тушаалаа ашиглан Банкны ашиг сонирхол, хувийн эрх ашигтай зөрчилдөх нөхцөл байдлыг бүрдүүлэн шууд буюу шууд бусаар хувийн болон 3.3-д заасан этгээдийн ашиг сонирхлоо хэрэгжүүлэх;

5.5.4 Банктай бизнесийн харилцаатай эсхүл бизнесийн харилцаа үүсгэх гэж байгаа хүн, хуулийн этгээдээс бэлэг, мөнгө, аливаа ашиг тус, давуу байдлыг хүсэх эсхүл хүлээн авах, бусдад нөлөөлөхийн тулд бэлэг, мөнгө, аливаа ашиг тус, давуу байдлыг санал болгох;

5.5.5 Банкны өмч хөрөнгийг хувийн ашиг сонирхолд ашиглах;

5.5.6 Ажил үүргийнхээ хүрээнд олж мэдсэн Банкны нууцлалтай, нийтэд ил болоогүй, дотоод буюу тусгай мэдээллийг Банкны эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц арга хэлбэрээр ашиглах, задруулах;

5.5.7 Банкны үйл ажиллагаа, эрх ашигт хамаарах аливаа ажлыг бизнес түншүүд, харилцагч, бусад оролцогч тал болон өрсөлдөгчийн ашиг сонирхолд нийцүүлэн гүйцэтгэх;

5.5.8 Банкны бизнес түншүүд, харилцагч, бусад оролцогч тал эсвэл өрсөлдөгчөөс шууд буюу шууд бус замаар санхүүгийн буюу эдийн засгийн ашиг хүртэх.

ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ТОЛИЛУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

6.1. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь тэдний хувийн сонирхол, Банкны ашиг сонирхолтой ил, далд зөрчилдөх нөхцөлд мэдрэмтгий хандаж ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь тэдний хувийн ашиг сонирхол, албан тушаалын эрх, үүрэгтэй зөрчилдөх тохиолдлуудыг мэдэж байх шаардлагатай.

6.2. ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд нь өөрийн болон бараа, үйлчилгээний бодит буюу боломжит нийлүүлэгч, хөрөнгө хүлээн авагч хоорондын сонирхлын зөрчил эсвэл холбоо хамаарлыг мэдээлэх, эсвэл өөрийн хувийн ашиг сонирхол нь Банкны

ашиг сонирхолтой зөрчилдсөн, өрсөлдсөн нөхцөл байдлын талаар мэдэгдэх үүрэгтэй.

- 6.3. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь өөрийн албан үүргийн гүйцэтгэлд нөлөөлж болохуйц аливаа хувийн, санхүүгийн болон бусад ашиг сонирхлоо толилуулах үүрэгтэй.
- 6.4. ТУЗ-ийн гишүүд, ажилтнуудын өөрийн болон бусдын хувийн үзэл бодол нь тэдгээрийн шийдвэрийн бодит чанар болон шударга байдалд сөргөөр нөлөөлөхөөс сэргийлнэ.
- 6.5. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь албан тушаалын эрх мэдлээ ашиглан (эсхүл ашигласан) бизнесийн түншүүд, харилцагчидтай тусгай харилцаатай байж, хувийн ашиг сонирхолд нь шууд буюу шууд бусаар хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийг санал болгохыг хориглоно.
- 6.6. Энэхүү Кодекс болон холбогдох бусад дүрэм, журмын дагуу Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсхүл Гүйцэтгэх захиралд бичгээр өөрийн ашиг сонирхлоо бүрэн толилуулснаас бусад тохиолдолд ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь Банкинд бараа, үйлчилгээ үзүүлэх бизнес түншүүдэд ажиллах, хувьцааг нь эзэмших, хамтран аливаа бизнесийн үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
- 6.7. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь албан үүргээ гүйцэтгэж байх үедээ олж авсан аливаа барилга байгууламж, өмч хөрөнгө, тоног төхөөрөмж, мэдээллийг Банк дах өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхээс бусад зорилгоор ашиглахгүй байна.
- 6.8. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь дараах этгээдийн зөвлөх, удирдлага, албан хаагч, ажилтан байж болохгүй буюу дараах үйл ажиллагааг эрхлэгч байж болохгүй. Үүнд:
 - 6.8.1. Банкны одоогийн буюу ирээдүйн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй өрсөлдөхүйц бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд нэвтрүүлдэг өрсөлдөгч;
 - 6.8.2. Бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас гадуур Банканд бараа үйлчилгээ нийлүүлэгч;
 - 6.8.3. Бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас гадуур Банкнаас бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авагч.
- 6.9. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь албан үүргээ гүйцэтгэсний төлөө Банкнаас олгох ашиг, орлого олохоос бусад тохиолдолд хувийн ашиг, орлого өгөхийг шаардах, хүлээж авахыг хориглоно.
- 6.10. ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд нь Банкны ТУЗ-ийн бусад гишүүдийн зөвшөөрснөөс

бусад тохиолдолд энэхүү Кодексод заасан сонирхлын зөрчлийн шинжтэй аливаа хэлэлцүүлэгт оролцохоос татгалзаж, санал хураалтад оролцохгүй байх үүрэгтэй.

- 6.11. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь энэхүү Кодексийн 5.4-д заасан сонирхлын зөрчил үүссэн гэж үзэх үндэслэлтэй байвал Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга эсвэл Гүйцэтгэх захиралд мэдээлэх замаар “шүгэл үлээх” үүрэгтэй.

ДОЛООДУГААР ЗҮЙЛ. САНХҮҮГИЙН АШИГ СОНИРХОЛ

- 7.1. ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд нь өөрийн албан үүргээ гүйцэтгэж байхдаа үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ авах үедээ хуримтлуулсан хоёрдогч санхүүгийн ашиг, хувийн ашиг орлогоо толилуулах үүрэгтэй.
- 7.2. Банкны ТУЗ-ийн гишүүд, ажилтнууд нь Банкны буюу түүний хувьцаа эзэмшигчдийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байхдаа гэрээлэгч буюу нийлүүлэгчтэй тогтоосон аливаа санхүүгийн холбоо, ашиг сонирхлоо толилуулах үүрэгтэй.
- 7.3. “Санхүүгийн холбоо” гэдэгт мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх бөгөөд дор дурдсанаас хязгаарлагдахгүй аливаа тодорхойлолтыг хэлнэ. Үүнд:
- 7.3.1. Цалин, рояалти, шагнал, зөвлөх үйлчилгээний хөлс, төлбөр зэрэг бусад орлого.
- 7.3.2. Хувьцаа, хувьцааны опцион зэрэг хувьцааны эрх, үл хөдлөх хөрөнгө, газар, бусад өмчийн эрх буюу өмчийн хөрөнгө оруулалт.
- 7.3.3. Патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх, зохиогчийн эрхийн төлбөр зэрэг оюуны өмчийн эрх.
- 7.3.4. Банкны шийдвэр, үйл ажиллагаанаас шууд хамааралтай үйл ажиллагаа эрхэлдэг, эсвэл одоо хувьцааг нь эзэмшдэг болон ирээдүйд хөрөнгө оруулж, хувьцаа эзэмшиж болзошгүй Банктай гэрээ, хэлцэл хийсэн буюу хийж буй аж ахуйн нэгж, хувь хүн.

НАЙМДУГААР ЗҮЙЛ. СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ

- 8.1 Сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд нийт ажилтнууд хариуцлагатай хандаж, ёс зүйн байдалд тулгарч буй асуудлаа өөрийн удирдлагад мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдсэн нь хангалттай үр дүнд хүрэхгүй бол уг асуудлыг хариуцсан ажилтанд танилцуулж тодруулга авна. Мэдээлэгч нь хариуцсан ажилтанд мэдээллийг нууцаар, шууд өгөх эрхтэй бөгөөд Хариуцсан ажилтан нь энэхүү мэдээллийг аудитын хороонд шилжүүлж ёс зүйн кодексод харш үйл ажиллагаа явуулсан тухайн ТУЗ-ийн гишүүн болон ажилтанд зохих арга хэмжээ авах саналыг

оруулна.

- 8.2 Хэрэв толилуулагдаагүй нуугдмал сонирхлын зөрчил байгаа тохиолдолд ТУЗ-ийн гишүүд нь ТУЗ-ийн нарийн бичгийн даргад нөхцөл байдлыг шуурхай мэдээлнэ. Энэхүү мэдээлэлтэй Гүйцэтгэх захирал болон ТУЗ-ийн дарга шаардлагатай бол ТУЗ танилцаж Кодексийн заалтын дагуу тухайн хэлцлийг бусад нөхцөл байдалтай уялдуулан судална.
- 8.3 ТУЗ-ийн гишүүд жил бүр дараах мэдээллийг тусгасан Сонирхлын зөрчлийн толилуулгын мэдэгдэлд гарын үсэг зурж баталгаажуулна.
 - 8.3.1 Кодексийн хувийг хүлээн авсан эсэх;
 - 8.3.2 Кодексийг уншиж, танилцаж ойлгосон эсэх;
 - 8.3.3 Кодексийг дагаж мөрдөхийг зөвшөөрсөн эсэх.
- 8.4 Сонирхлын зөрчлийн хагас жилийн толилуулгыг жил бүрийн 2 дугаар улирал дуусахаас өмнө гаргана.
- 8.5 Сонирхлын зөрчилтэй хэлцэл илэрсэн тохиолдолд тухайн хэлцэлд холбогдсон ТУЗ-ийн гишүүн нь тухайн асуудлаар шийдвэр гаргах бусад эрх бүхий этгээдэд нөлөөлөхийг оролдох, шаардлагатай мэдээлэл өгөхөөс бусад тохиолдолд тухайн хэлцэлд хамаарах хэлэлцүүлэгт орохыг хориглоно.
- 8.6 Сонирхлын зөрчлийн талаар мэдээлсэн ажилтны нэр, тухайн сонирхлын зөрчлийн шинж чанар, холбогдох харьцуулсан тоон мэдээлэл (салбарын шинжилгээ, нөхөн төлбөрийн судалгаа, тендер гэх мэт) зэрэг Банкнаас тухайн гүйлгээ, хэлцлийг хийхийг тодорхойлсон хэлэлцүүлгийг хурлын тэмдэглэлд эсхүл холбогдох баримт бичигт тусгана.
- 8.7 ТУЗ-ийн Аудитын хороо нь Банкнаас Төрийн эрх бүхий байгууллагын оролцоотой төсөлд хамтран ажиллах хүсэлт гаргах болон хамтран ажиллахдаа холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангаж байгаа эсэх, ил тод, хараат бус ажиллаж байгаа эсэхэд хяналт тавина.
- 8.8 Харьцуулсан тоон мэдээллийг хурлын тэмдэглэлд эсхүл холбогдох баримт бичигт тусгаж, баримтжуулна.
- 8.9 Банкны хийхээр төлөвлөж буй хэлцэлд Банкны ТУЗ-ийн гишүүн нь сонирхлын зөрчилтэй байх тохиолдолд тухайн сонирхлын зөрчлийн талаар ТУЗ-ийн холбогдох хуралд мэдэгдэх бөгөөд ТУЗ-ийн гишүүн нь тус хэлцэлд шууд болон шууд бусаар сонирхлын зөрчил үүсэж болзошгүй талаар мэдсэн дараа болох ТУЗ-ийн анхны хурлаар сонирхлын зөрчлийн талаар мэдэгдэх үүрэгтэй.
- 8.10 Банкны ТУЗ-ийн гишүүн нь сонирхлын зөрчлийн шинж чанарыг тусгасан мэдэгдлийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан эсхүл ТУЗ-ийн хуралд оролцож биечлэн мэдэгдэнэ.

- 8.11 Холбогдох хэлцлийг батлах тогтоол гаргаж буй ТУЗ-ийн хурал, бусад үйл ажиллагаа, саналд тухайн хэлцэлд шууд болон шууд бусаар сонирхлын зөрчилтэй ТУЗ-ийн гишүүн нь санал өгөх, ирц бүрдүүлэх зэргээр оролцохгүй.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ. КОМПАНИЙН ХАРИУЦЛАГА БА ЗАРЧИМЧ БАЙДАЛ

- 9.1. ТУЗ-ийн гишүүн ба ажилтнууд нь Банканд ажиллахын тулд өөрийн мэргэшил, мэргэжил ур чадварын талаар худал мэдээлэл өгч болохгүй.
- 9.2. Нийт ТУЗ-ийн гишүүн болон ажилтан энэхүү Кодексод заасан зарчим, ёс зүйн шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөө бэлэг, шан харамж, хөнгөлөлт, төлбөр, шимтгэл, үнэгүй үйлчилгээ, зээл, зугаалга гэх мэт зүйлсэд хамаарах зохицуулалтыг хатуу мөрдөх ёстой.
- 9.3. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд энэхүү Кодексод заасан зарчим, хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хэзээ, хаана зөрчил гарснаас үл хамааран тухай бүр хатуу арга хэмжээ авна.

АРАВДУГААР ЗҮЙЛ. НУУЦЛАЛ

- 10.1. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь Банкнаас задруулах зөвшөөрөл олгосноос бусад тохиолдолд Банкны холбогдох нууц хадгалах, дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжааны тухай, нууцлалын тухай журам зэрэг эрх зүйн зохицуулалтыг дагаж мөрдөнө, мөн Банк болон Банкны нийлүүлэгч, харилцагч зэрэг бизнес түншүүдийн нууцыг хадгалах үүрэгтэй.
- 10.2. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь өөрийн албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажилд томилогдох, ажилд орох үедээ олж авсан мэдээллийн нууцыг хамгаалах бөгөөд зөвшөөрөл олгоогүй нөхцөлд аливаа хэлбэрээр задруулж болохгүй. Мөн ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь нууц мэдээллийг (албан үүргээ гүйцэтгэж байхдаа олж авсан) өөрт болон бусад этгээдэд давуу байдал олгох зорилгоор ашиглахыг хориглоно.
- 10.3. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнууд нь Банканд ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөлөгдсөнөөс хойш нэг жилийн хугацаанд олж авсан нууц мэдээллийг Банкны хүсэл зоригт нийцэхгүй байдлаар задруулах, ашиглахыг хориглоно.
- 10.4. “Нууц мэдээлэл” гэдэгт дараах мэдээлэл хамаарна. Үүнд:
- 10.4.1. “Нууц”, “Хувийн”, “Зөвхөн дотоод албан хэрэгцээнд”, “Нийтэд ил болоогүй мэдээлэл” гэж тэмдэглэгдсэн болон үүнтэй ижил төстэй үгээр тэмдэглэгдсэн мэдээлэл.
- 10.4.2. Одоогийн болон ирээдүйн бүтээгдэхүүн, үйлчилгээ, судалгаа, түншлэл

болон компанийг нэгтгэх, нийлүүлэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл.

10.4.3. Бизнесийн буюу маркетингийн төлөвлөгөө, төсөл.

10.4.4. Орлого болон санхүүгийн бусад дотоод мэдээлэл буюу их хэмжээний мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл.

10.4.5. Хүний нөөц ба удирдлагын өөрчлөлтийн талаарх мэдээлэл.

10.4.6. Харилцагчдын жагсаалт ба мэдээлэл.

10.4.7. Задруулсан тохиолдолд өрсөлдөгчид ашигтай эсхүл Банкны харилцагч, бизнес түншүүдэд хохирол учруулж болзошгүй нийтэд ил болоогүй бусад мэдээлэл болон дотоод мэдээлэл эзэмшигчийн арилжаанд ашиглагдсан мэдээлэл.

10.4.8. Монгол Улсын үнэт цаасны зах зээлийн тухай хууль тогтоомжид заасан бусад дотоод мэдээлэл.

АРВАННЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХУУЛЬ ТОГТООМЖ БА ЗАСАГЛАЛ

- 11.1. Банк нь өөрийн бизнесийн үйл ажиллагааг явуулахдаа хуульд заасан үүргийг хүлээнэ. Эдгээр үүрэг нь холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй байдал болон бусад холбогдох стандарт, оюуны өмчийн тухай зохицуулалт, бусад ёс зүйн баримт бичигт тусгагдсан байна.
- 11.2. Банк нь гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, хариуцлагатай хэрэгжүүлэх байгаа эсэхэд ТУЗ-ийн гишүүд хяналт тавина.
- 11.3. Банкны зорилго, хөтөлбөр, санхүү ба засаглалд хамаарах мэдээллийг нээлттэй бөгөөд бодитойгоор толилуулах зэргээс гадна хувь хүний болон байгууллагын нууцын шаардлагыг хүндэтгэх асуудал багтана.

АРВАНХОЁРДУГААР ЗҮЙЛ. НИЙТЭД ХИЙХ МЭДЭГДЭЛ

- 12.1. ТУЗ-ийн гишүүн болон ажилтан нь ажил, албан үүргийнхээ дагуу олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд мэдэгдэл хийх, ярилцлагад орох, санал илэрхийлэх тохиолдолд дараах шаардлагыг биелүүлнэ. Үүнд:

12.1.1. Банкны нэрийн өмнөөс мэдэгдэл хийхдээ холбогдох зөвшөөрөл, эрхийг авсан байх;

12.1.2. Үйл баримттай холбоотой өөрийн үзэл бодлыг ТУЗ-ийн бусад гишүүдийн

саналтай нийцэхгүй гэдгийг мэдсээр байж илэрхийлж буй тохиолдолд, тухайн санал нь өөрийн хувийн санал бодол гэдгийг тодорхой мэдэгдэх.

12.1.3. Гарч болзошгүй үр дагаврыг нь анхааралтай тооцохгүйгээр аливаа саналыг илэрхийлэхгүй.

- 12.2. ТУЗ-ийн гишүүн нь өөрийгөө олон нийт болон уншигчдын дунд албан эх сурвалжид тооцогдож, илэрхийлсэн үг нь ишлэгдэж болохыг санах ёстой.
- 12.3. ТУЗ-ийн гишүүн бүр амаар болон бичгээр мэдэгдэл хийхдээ ийнхүү мэдэгдэл хийх болсон шалтгаан, бүрэн эрх, мөн хэний нэрийн өмнөөс илэрхийлж байгааг тодорхой мэдэгдэнэ.
- 12.4. ТУЗ-ийн гишүүн бүр нийтэд ил болоогүй мэдээллийг задруулахгүй байх тал дээр анхаарах ёстой.
- 12.5. ТУЗ-ийн гишүүд Банкны бизнесийн болон ажил хэргийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй улс төрийн мэдэгдэл (амаар болон бичгээр) хийхгүй байх, мөн улс төрийн үзэл бодлоо илэрхийлэхгүй байх ёстой.
- 12.6. ТУЗ-ийн гишүүн, ажилтны олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан илэрхийлж буй санал, сэтгэгдэл, үйлдэл, эс үйлдэл нь Банкны үнэт зүйлс, баримтлах зарчим болон холбогдох эрх зүйн баримт бичгийн эсрэг бус, аливаа сөрөг үр дагавар үүсгэхээргүй байна.
- 12.7. ТУЗ-ийн гишүүн, ажилтнууд нь аливаа олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглахдаа Банкны холбогдох заавар, зөвлөмжийг баримтална.

АРВАНГУРАВДУГААР ЗҮЙЛ. ГЭМ БУРУУТАЙ НЬ ТОГТООГДОХ

- 13.1. ТУЗ-ийн гишүүн нь шударга бус ажиллагаанд хамаарах аливаа хэрэгт буруутгагдсан эсвэл Банкны нэр хүндэд сөргөөр нөлөөлөх асуудал гаргасан тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн даргад цаг алдалгүй мэдэгдэх ёстой.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. ХЯНАН НИЙЦҮҮЛЭХ ҮЙЛ ЯВЦ

- 14.1. ТУЗ-ийн гишүүн нь Банктай холбоотой аливаа этгээдийн хууль тогтоомж, гэрээгээ зөрчсөн буруутай үйл ажиллагааны талаарх нотлох баримтыг мэдсэн бол энэ тухай ТУЗ-ийн нарийн бичгийн даргад, холбогдох баримтыг Гүйцэтгэх захирал эсхүл ТУЗ-ийн даргад мэдэгдэх үүрэгтэй.
- 14.2. Дээрх асуудлын шинж чанараас хамаарч нэрээ нууцлах шаардлагатай бол Банкны аудиторуудад мэдэгдэнэ.
- 14.3. Банкны үнэт зүйлсийг үл хүндэтгэсэн, ёс зүйгүй, хариуцлагагүй, эсхүл хууль бус үйлдэл гаргасан тохиолдолд ТУЗ эсвэл түүний дэргэдэх холбогдох хороо нь тухайн үйлдлийг шалгана.

14.4. Мэдээлэл өгсөн хүн буюу “шүгэл үлээгч”-ийн нууцыг бүрэн хамгаална.

АРВАНТАВДУГААР ЗҮЙЛ. СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

- 15.1. ТУЗ-ийн гишүүн болон шинэ ажилтнуудад зориулан жилд нэг удаа ёс зүйн танилцуулга сургалт зохион байгуулна. Тус сургалт нь ёс зүй ба зан үйл, харилцаа, ёс зүйн хэм хэмжээ, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа, авлигаас урьдчилан сэргийлэх болон олон нийтэд мэдээлэх асуудлыг тусгасан байх ба үүгээр хязгаарлагдахгүй болно.
- 15.2. ТУЗ-ийн гишүүн болон ажилтнуудад, түүнчлэн нийлүүлэгч, бизнесийн түншүүд зэрэг компанийн бусад оролцогч талуудыг Банкны байнгын сургалтын хөтөлбөрийн хүрээнд дээрх сэдвээр зохион байгуулах тусгайлсан сургалтад хамруулна.